



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/600

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.5.2, 1.1.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Музейн ан амьтны танхимд халиун бугын чихмэл хийлгэх зардалд 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөг, Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэлийн зардалд 10,800,000 (арван сая найман зуун мянга) төгрөг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тохижилтын зардалд 9,915,000 (есөн сая есөн зуун арван таван мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардалд нийт 23,515,000 (хорин гурван сая таван зуун арван таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101273